



**АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН МЭРГЭЖЛИЙН ХОЛБОО
НИЙТИЙН ЭРХ ЗҮЙН ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2026 оны 04 сарын 09 өдөр

Дугаар 300.126

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Аялал жуулчлалын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дахь хэсэг, Аялал жуулчлалын мэргэжлийн холбооны дүрмийн 28 дугаар зүйлийн 28.1.3 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 03 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагын ангилал, зэрэглэлийг тогтоох, олгох, бууруулах, хүчингүй болгох болон уг үйл ажиллагааны үйлчилгээний хөлстэй холбоотой журам”-ын 3 дугаар зүйлийн 3.4 дэх хэсгийг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо НЭЗХЭ-ийн “аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагын зэрэглэлийг тогтоох комиссын ажиллах журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ө.МӨНХНАСАН

“Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо” НЭЗХЭ-ийн
Удирдах зөвлөлийн 2026 оны 03 сарын 09 өдрийн
20-тоот тогтоолын хавсралт



АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГЫН ЗЭРЭГЛЭЛИЙГ ТОГТООХ КОМИССЫН АЖИЛЛАХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү журмын зорилго нь Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 03 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагын ангилал, зэрэглэлийг тогтоох, олгох, бууруулах, хүчингүй болгох болон уг үйл ажиллагааны үйлчилгээний хөлстэй холбоотой журам”-ын хэрэгжилтийг хангах, зэрэглэл тогтоох комиссын үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2. Энэхүү журмыг Аялал жуулчлалын тухай хуулийн 26.1-д заасан “Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо” нийтийн эрх зүйн хуулийн этгээд /цаашид “Мэргэжлийн холбоо” гэх/, Мэргэжлийн холбооноос томилогдсон аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагын зэрэглэл тогтоох комисс үйл ажиллагаандаа баримтална.

1.3. Аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагын зэрэглэл тогтоох комисс /цаашид “Комисс” гэх/ үйл ажиллагаандаа Аялал жуулчлалын тухай хууль, “Аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагын ангилал, зэрэглэлийг тогтоох, олгох, бууруулах, хүчингүй болгох болон уг үйл ажиллагааны үйлчилгээний хөлстэй холбоотой журам”, энэхүү журам болон холбогдох бусад эрх зүйн актыг баримтална.

ХОЁР. КОМИСС БАЙГУУЛАХ

2.1. Зэрэглэл тогтоох комиссын бүрэлдэхүүнийг “Аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагын ангилал, зэрэглэлийг тогтоох, олгох, бууруулах, хүчингүй болгох болон уг үйл ажиллагааны үйлчилгээний хөлстэй холбоотой журам”-ын 3.3, 3.5-д заасан бүрэлдэхүүнтэй байгуулна.

2.2. Мэргэжлийн холбооноос байгуулагдсан комиссын ажиллах хугацаа нь 3 сараас илүүгүй байна.

2.3. Мэргэжлийн холбоо хүсэлт гаргасан байгууллагын тооноос хамааран зэрэглэл тогтоох хэд хэдэн комиссыг зэрэг байгуулж болно.

2.4. Мэргэжлийн холбооноос томилох комиссын гишүүн дараах шаардлагыг хангасан байна:

2.4.1. дээд боловсролтой байх;

2.4.2. аялал жуулчлалын салбарт 5-аас дээш жил ажилласан;

2.4.3.үйлчилгээний байгууллагын чанарын зэрэглэлд үнэлгээ, дүгнэлт өгөх, багаар ажиллаж, асуудал шийдвэрлэх ур чадвартай байх;

2.4.4.шүүхийн шийдвэрээр ял шийтгэл эдэлж байгаагүй байх;

2.4.5.зэрэглэл тогтоох үйл ажиллагаанд ашиг сонирхлын зөрчилгүй байх;

2.4.6.аялал жуулчлалын салбарын хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан хэм хэмжээний актын талаар мэдлэгтэй байх;

2.4.7.шинжээчийн сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байх;

2.5.Энэ журмын 2.3-т заасны дагуу хэд хэдэн комиссыг зэрэг байгуулсан тохиолдолд комисс тус бүрийн удирдамжийг батална.

2.6.Комисс байгуулах саналыг Мэргэжлийн холбооны хууль эрх зүй, хөрөнгө оруулалтын чиг үүргийн хороо боловсруулж, Удирдах зөвлөлд танилцуулж, батлуулна.

2.7.Мэргэжлийн холбоо комиссын гишүүдтэй ажиллах нөхцөл, эрх, үүрэг, хөлс, хариуцлагын асуудлыг тусгасан гэрээг ажлын 5 хоногийн дотор байгуулна.

2.8.Комиссын даргыг гишүүд дотроосоо илээр санал хурааж сонгоно.

2.9.Комиссын нарийн бичгийн даргыг Мэргэжлийн холбооноос томилно.

ГУРАВ.КОМИССЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

3.1. Комисс зэрэглэл тогтоох үйл ажиллагааг доорх дарааллаар явуулна:

3.1.1.мэргэжлийн холбоонд ирүүлсэн зэрэглэл тогтоолгох хүсэлт, өөрийн үнэлгээний тайланг ажлын 10 хоногт багтаан нягтлан, хариу өгөх;

3.1.2.удирдамжийн дагуу төлөвлөгөө гарган, очиж ажиллах;

3.1.3.хүсэлт гаргасан байгууллагад очиж ажиллахдаа Мэргэжлийн холбооноос батлагдсан маягт, холбогдох стандартын дагуу үнэлгээ хийх;

3.1.4.тухайн байгууллагад ажилласнаас хойш 1 хоногийн дотор 100 хувийн ирцтэйгээр хуралдаж зэрэглэл олгох эсэх тухай дүгнэлтийг гаргах;

3.1.5.байгууллагын хүсэлтэд заасан одны зэрэглэлд комиссын гишүүдээс өгсөн үнэлгээний дундаж оноо Аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагын ангилал, зэрэглэлийг тогтоох, олгох, бууруулах, хүчингүй болгох болон уг үйл ажиллагааны үйлчилгээний хөлстэй холбоотой журмын 2.4-т заасан ононд хүрээгүй тохиолдолд оноо нэмэгдүүлэх хугацаат даалгаврыг тухайн байгууллагад өгч болно;

3.1.6.зэрэглэл олгох эсэх тухай дүгнэлт гаргаснаас хойш ажлын 5 хоногийн дотор комиссын үйл ажиллагааны тайланг Мэргэжлийн холбоонд хүргүүлэх.

3.2.Комисс энэ журмын 3.1.4-д заасан дүгнэлтийг гаргахдаа “Аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагын ангилал, зэрэглэлийг тогтоох, олгох, бууруулах, хүчингүй болгох болон уг үйл ажиллагааны үйлчилгээний хөлстэй холбоотой” журмын 2.4-т заасан онооны шаардлагыг баримтална.

3.3.Комисс тухайн байгууллагад очиж ажиллахдаа тэмдэглэл үйлдэж, дүрс бичлэгээр баталгаажуулах бөгөөд тэмдэглэлийг хүсэлт гаргасан байгууллагын эрх бүхий ажилтнаар гарын үсэг зуруулж, баталгаажуулна.

3.4.Комисс тухайн байгууллагад очиж ажиллахдаа 1-2 одны зэрэглэл тогтооход 1 хоног, 3-5 одны зэрэглэл тогтооход 2 хоног хүртэлх хоногийн хугацаанд бүрэлдэхүүнээр ажиллана.

3.5.Хүсэлт гаргасан байгууллагад очиж ажиллах, байрлах бэлтгэл, зэрэглэл тогтоох ажлыг зохион байгуулахтай холбоотой бусад ажлыг Комиссын нарийн бичгийн дарга хариуцна.

3.6.Комиссын нарийн бичгийн дарга хүсэлт гаргасан байгууллагад очиж ажиллахаас өмнө тухайн байгууллагад урьдчилан мэдэгдэнэ.

3.7.Комиссын дарга болон гишүүн хүндэтгэн үзэх шалтгааны улмаас ажиллах боломжгүй болсон бол томилсон байгууллагаас нөхөн томилно.

ДӨРӨВ. КОМИССЫН БҮРЭН ЭРХ

4.1.Комисс дараах эрх, үүрэгтэй:

4.1.1.байгууллагын зэрэглэл тогтоолгох хүсэлт гаргагч этгээдийн үйл ажиллагаатай танилцаж үнэлгээ өгөх;

4.1.2.комиссын хуралдаанаар байгууллагад стандартын шаардлага хангаж байгаа эсэхэд үнэн зөв, мэргэжлийн үнэлгээ өгч, зэрэглэл олгох эсэх талаар дүгнэлт гаргах;

4.1.3.шаардлагатай тохиолдолд байгууллагын зэрэглэл тогтоох үйл ажиллагааг сайжруулах санал боловсруулах;

4.1.4.зэрэглэл тогтоолгох хүсэлт гаргасан байгууллагаас ирүүлсэн танилцуулга, өөрийн үнэлгээний тайлан, холбогдох материалтай хуралдааны өмнө урьдчилан танилцсан байх;

4.1.5.Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Байгууллагын нууцын тухай хуулийг баримтлах, комиссын үйл ажиллагаатай холбоотой олж мэдсэн мэдээллийг задруулахгүй байх.

4.1.6.комиссын үйл ажиллагааны тайланг энэ журамд заасан хугацаанд Мэргэжлийн холбоонд хүргүүлэх.

4.2.Комиссын дарга дараах эрх, үүрэгтэй:

4.2.1.комиссын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;

4.2.2.комиссын хурлын тов тогтоох, хурлын дэгийг батлах, мөрдүүлэх, хурлыг удирдах;

4.2.3.комиссын нарийн бичгийн дарга, гишүүдэд комиссын үйл ажиллагаатай холбоотой үүрэг даалгавар өгөх, түүний биелэлтэд хяналт тавих;

4.2.4.комиссын үйл ажиллагааны тайлан, хурлын тэмдэглэлийг баталгаажуулах.

4.3.Комиссын нарийн бичгийн дарга дараах эрх, үүрэгтэй:

4.3.1.комиссын хуралдааны бэлтгэл ажлын зохион байгуулалтыг хангах, хурлын тэмдэглэл хөглөх;

4.3.2.зэрэглэл тогтоолгоход шаардлагатай зөвлөгөө, мэдээлэл өгөх;

4.3.3.хүсэлт гаргасан байгууллагатай холбогдох шаардлагатай мэдээллийг гаргуулан авах;

4.3.4.хэлэлцэх асуудлын төлөвлөгөө, холбогдох материалыг комиссын гишүүдэд комиссын хурал болохоос ажлын 5-аас доошгүй хоногийн өмнө хэвлэмэл, эсхүл, цахим хэлбэрээр хүргүүлэх;

4.3.5.комиссын хурлаар хэлэлцсэн асуудлаар тэмдэглэл болон шийдвэр, дүгнэлтийг дарга, гишүүдээр гарын үсэг зуруулж баталгаажуулах, мэдээлэх;

4.4.Комиссын нарийн бичгийн дарга комиссын хуралдаанд оролцохдоо хэлэлцэх асуудалд саналын эрхгүй оролцоно.

ТАВ. КОМИССЫН ХУРАЛ

5.1.Хуралд нийт гишүүдийн 50-аас дээш хувь хүрснээр хурлын ирц хүчинтэй болно.

5.2.Комиссын хурлаар шийдвэр, дүгнэлт гаргахад олонхын дэмжсэнээр тухайн шийдвэр, дүгнэлтийг батлагдсан тооцно.

5.3.Комиссын шийдвэр, дүгнэлтэд комиссын дарга, гишүүд гарын үсэг зурж баталгаажуулна.

5.4.Хурлын тэмдэглэлд комиссын гишүүд гарын үсэг зурж баталгаажуулна.

ЗУРГАА. ЁС ЗҮЙН ХЭМ ХЭМЖЭЭ

6.1.Комиссын дарга, гишүүд өөрт олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ ашиг сонирхлын зөрчил үүсгэж болзошгүй дараах үйл ажиллагаанаас сэргийлж ажиллана:

6.1.1.ашиг сонирхлын зөрчилтэй асуудлаар шийдвэр, дүгнэлт гаргах, албаны нэр барих зэргээр комиссын гишүүний эрхийг буруугаар ашиглах;

6.1.2.бүрэн эрхээ урвуулан ашиглах, бусдыг дарамтлах үйлдэл, эс үйлдэхүй гаргах;

6.1.3.бусад гишүүдийн үйл ажиллагаанд хууль бусаар нөлөөлөх, саад болох, үйлдэл хийхийг шаардах, үүрэг даалгавар өгөхийг хориглох;

6.1.4.комиссын гишүүд зүй бус үйлдэл харилцаа гаргахгүй байх;

6.1.5.авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;

6.1.6.Комиссын үнэлгээ нь шударга, бодитой, ашиг сонирхлын зөрчил, нөлөөллөөс ангид байх;

6.2.Комисс дарга, гишүүд, нарийн бичгийн дарга нь энэ журмын 6.1-д заасныг зөрчсөн тохиолдолд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээнэ.

ДОЛОО.БУСАД

7.1.Аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагын зэрэглэл тогтоох үйлчилгээний хөлс хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлснээс багагүй хэмжээтэй байна.

7.2.Энэ журмын 7.1-д заасан үйлчилгээний хөлсөнд дараах зардал багтана:

7.2.1.комиссын дарга, гишүүн, нарийн бичгийн даргын ажлын хөлс;

7.3.Аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагын зэрэглэл тогтоох үйлчилгээний хөлсөнд комиссын гишүүний тээврийн зардал, байр, хоолны зардал ороогүй бөгөөд тухайн зардлыг хүсэлт гаргасан байгууллага хариуцна.

7.4.Энэ журмын 7.3-г заасан тээвэр, байр, хоолны зардлыг гаргахад санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан “Дотоод албан томилолтын зардлын хэмжээ”-г баримтална.

7.5.Энэ журамд заасан комиссын дарга, гишүүн, нарийн бичгийн дарга ажлын хөлсийг батлагдсан удирдамжид заасны дагуу тооцож Мэргэжлийн холбоо комиссын нарийн бичгийн даргын бүртгэсэн цагийн бүртгэлд тооцож олгоно.

---oOo---